



**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2023 оны 07 сарын 07 өдөр

Дугаар 07/454

Арвайхээр сум

**Газар эзэмших эрх нэгтгэх тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх заалт, Газрын тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.4, 38.6 дахь хэсэг, Газар зохион байгуулалт, геодези зураг зүйн газрын даргын 2021 оны А/187 дугаар тушаалаар батлагдсан Газар эзэмших, ашиглах эрхийн гэрчилгээ олгох журмын 8.1.4 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Арвайхээр сумын инженерийн шугам сүлжээ бүхий газарт байрлах 3 нэгж талбарыг эзэмшигчдийн хүсэлтийн дагуу хавсралтад зааснаар газар эзэмших эрхийг нэгтгэсүгэй.

2. Дээрх газар эзэмших эрхэд гарсан өөрчлөлтийг газрын улсын бүртгэлд бүртгэж, гэрээг зохих журмын дагуу байгуулан, гэрчилгээ олгохыг аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлаг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар (Т.Ариунболд)-т үүрэг болгосугай.

3. Энэхүү захирамж гарсантай холбогдуулан аймгийн Засаг даргын 2023 оны 07 дугаар сарын 04-ний өдрийн "Газар эзэмших эрхийн гэрчилгээг бусдад шилжүүлэх тухай" А/439 дүгээр захирамжийн хавсралтын "Өв гурван лут" ХХК-тай холбогдох хэсгүүдийг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА



А.ИШДОРЖ

6223 11 0888

D:My Doc. Zahiramj. Zasag darga



ГАЗАР ЭЗЭМШИХ ЭРХ НЭГТГЭЖ БУЙ НЭГЖ ТАЛБАРЫН МЭДЭЭЛЭЛ

Д/Д	Газар эзэмшигчийн овог, нэр (Хуулийн этгээдийн нэр)	Эзэмшигчийн регистрийн дугаар	Газрын зориулалт	Газрын хэмжээ (м <sup>2</sup> )	Нэгж талбарын дугаар	Газар эзэмших эрх шилжүүлэн авагчийн овог, нэр (Хуулийн этгээдийн нэр)	Эрх шилжүүлэн эзэмшигчийн регистрийн дугаар	Газрын зориулалт	Газрын хэмжээ (м <sup>2</sup> )	Газрын байршлын нэр, хаяг	Эзэмших хугацаа
1	Өв гурван лут ХХК	3562514	5-8 давхар нийтийн орон сууц	500	6216031819	Өв гурван лут ХХК	3562514	5-8 давхар нийтийн орон сууц	1500	13 дугаар баг, Залуучууд-1 гудамж, 122 тоот	11 жил
2	Өв гурван лут ХХК	3562514	5-8 давхар нийтийн орон сууц	500	6216030088						
3	Өв гурван лут ХХК	3562514	5-8 давхар нийтийн орон сууц	500	6216030085						